



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 115,583,000.00 (нэг зуун арван таван сая таван зуун наян гурван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирал О.Доржсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001759



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
215 дугаар тогтоолын хавсралт

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргэн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Мазда бонго, 93-29 УБЛ, арал №SE28T300284	1996/ 2005	91023	5,956,000.00	5,956,000.00	0	0	1,000,000.00	250,000.00
2	Хьюндай автобус, 49-32 УБЗ, арал №L4614413	2000/ 2000	39500	95,877,000.00	95,877,000.00	0	0	1,000,000.00	250,000.00
3	Киа Оптима, 05-13 УБЗ, арал №30182	2001/ 2002	49157	13,750,000.00	13,750,000.00	0	0	1,000,000.00	250,000.00
	Нийт дүн			115,583,000.00 (нэг зуун арван таван сая таван зуун наян гурван мянган)	115,583,000.00 (нэг зуун арван таван сая таван зуун наян гурван мянган)	0	0	3,000,000.00 (гурван сая)	